

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/12

Өлгий

Г

Т

Өвөлжилт хүндэрсэн сумдын эрүүл  
мэндийн тусламж үйлчилгээний хариу арга  
хэмжээний чадавхыг бэхжүүлэх  
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6, 8, 9, 10 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах тухай 2022 оны А/550 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн сумдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх ажлын удирдамжийг 1 дүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар, сумдад ажиллах хуваарийг 3 дугаар, зарцуулах төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумдад зарцуулагдах 29,711,600 /хорин есөн сая долоон зуун арван нэгэн мянга зургаан зуун төгрөг / төгрөгийг Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч /Х.Лена/-д зөвшөөрсүгэй.

3. Үйл ажиллагааны зохион байгуулалтыг ханган, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга /М.Рустем/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.САКЕН



Эрүүл мэндийн газрын даргын  
2023...оны...09...сарын...10...өдрийн...11/2...тоот  
тушаалын ...нээхүүжүүлэх...хавсралт

## ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

### ҮНДЭСЛЭЛ:

Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд 2023 оны 01 дүгээр сарын 06 байдлаар Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Сүхбаатар, Хэнтий зэрэг 8 аймаг зудын байдалтай байсан бол 2023 оны 01 дүгээр сарын 06 байдлаар Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Сүхбаатар, Хэнтий, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл зэрэг 11 аймгийн 22 суманд цагаан зудын, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Увс, Завхан, Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Сүхбаатар, Дорнод зэрэг 13 аймгийн 44 сум, нийслэлийн 1 дүүрэгт цагаанаар зудархуу байдалтай байна.

Баян-Өлгий аймаг нь 108376 хүн амтай, 14 сүмтэй, Улаанбаатар хотоос 1700 км зайдай. Аймгийн төвөөс хамгийн хол орших сум нь 320 км-т оршдог. 2023 оны 02 дугаар сарын 01-ний байдлаар Алтай, Булган, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумдад цагаан зудархуу байдалтай, аймгийн хэмжээнд гадны аймагт 0 өрхийн 0, өөрийн аймагт 244 өрхийн 702 иргэн нийт 244 өрхийн 702 иргэн отор нүүдлээр өвөлжиж байна. Тус аймагт зудын байдалтай байгаа сумдын иргэд болон отроор өвөлжиж байгаа нийт 702 иргэдийн дунд жирэмсэн эмэгтэй 4, 5-аас доош насны 59 хүүхэд, ахмад настай 36, хөгжлийн бэрхшээлтэй 3, архаг хууч өвчтэй 21 хүн байна.

Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой отроор өвөлжиж байгаа айл, өрхүүдийн ахмад настан, жирэмсэн эмэгтэй, 0-5 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, архаг хууч өвчтэй иргэдэд стандартын дагуу үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг давтамжтай үзүүлэхэд эрүүл мэндийн салбарын тусlamж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхэд алслагдсан байдлаас шалтгаалан шатахуун, томилолтын зардал хүрэлцэхгүй байна.

**ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:** Баян-Өлгий аймгийн ЭМГ

### ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД:

Эрүүл мэндийн газар- 4 албан хаагч, /2 мэргэжилтэн, 2 жолооч/  
Эх барих эмэгтэйчүүдийн эмч-1, хүүхдийн эмч-1, дотрын эмч-1, ЗДТГ-1  
мэргэжилтэн, ОБГ- 1 мэргэжилтэн, сумын эрүүл мэндийн төвийн эмч -2

**ХУГАЦАА:** 2023.03.09 – 2023.04.30

**САНХҮҮЖИЛТ:** ДЭМБ 29,711,600 төгрөг

**ЗОРИЛГО:** Аймгийн зудын үеийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх

### ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- КОВИД-19 цартахлын үед отроор өвөлжиж буй иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх

2. Анхан шатны эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг отроор өвөлжиж буй иргэдэд (ахмад настан, жирэмсэн эмэгтэй, бага насын хүүхэд гэх мэт) хүргэх

#### **ХҮРЭХ ҮР ДҮН:**

1. КОВИД-19 цартахлын үед отроор өвөлжиж буй иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг тасалдалгүй хүргэсэн байна.
2. Отроор өвөлжиж байгаа ахмад настан, жирэмсэн эмэгтэй, бага насын хүүхэд анхан шатны эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн газрын даргын  
2023...оны 03...сарын 01...өдрийн 11/12...тоот  
тушаалтын 10/03/2023...хавсралт

МОЕ0019

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцан эзэн
1	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх тушаалтыг боловсруулж, бэлтгэл ажлыг хангах	III/09-III/10	Х.Жанбота Б.Нуржайнар
2	Өвөлжилт хүндэрсэн сумдуудад отроор өвөлжиж буй иргэдийн судалгааг гаргах нэгтгэх /ахмад настан, жирэмсэн эмэгтэй, 0-5 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/	III/09-III/13	Х.Жанбота
3	Орон нутгийн нөхцөл байдалд зохицсон удирдамж гаргаж батлуулах	III/09-III/13	Х.Жанбота
4	Сумдад хуваарийн дагуу очиж ажиллах	III/13-IV/05	Хамтарсан багийн гишүүд
5	Сумдад ажилласан талаар тайлагнах	IV/01	Х.Жанбота
6	Сумдад хуваарийн дагуу 2 дахь ээлж очиж ажиллах	IV/05-IV/30	Хамтарсан багийн гишүүд
7	Хийсэн ажлын тайланг бичих, хянах баталгаажуулж хүргүүлэх	IV/30	Х.Жанбота Х.Лена

Эрүүл мэндийн газрын даргын  
сарын 10-өдрийн 11/2 тоот  
тушаалын түүрээлж хавсралт

ЛЮЕ0019

### СҮМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ:

№	Сумын нэр	/ Эхний ээлж / хугацаа	/ Давтан / хугацаа	Хариуцах эзэн
1	Цэнгэл сум	III/13-III/14	IV/05-IV/06	
2	Улаанхус сум	III/15-III/16	IV/10-IV/11	
3	Сагсай сум	III/27-IV/28	IV/12-IV/13	Хамтарсан багийн гишүүд хариуцана
4	Алтай сум	III/29-III/30	IV/17-IV/18	
5	Булган сум	IV/03-IV/04	IV/19-IV/20	

Эрүүл мэндийн газрын даргын  
сарын 10... едрийн 11/12... тоот  
тушаалын ... дээрээ булагч... хавсралт

**Өвөлжилт хүндээрсэн сумдын эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хариу  
арга хэмжээг чадавхыг бэхжүүлэх ажлын зардлын тооцоо**

N	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Давт амж	Тооцоолол	Дүн, ₮
1	Томилолт (жолоочийн томилолтыг оруулах )	хүн, хоног	64000	110	2	64,000 төгрөг *хүн*хоног	14,080,000
2	Шатахуун	км, литр	2700	11416	2	төгрөг*км *литр*0.25	15,411,600
3	Харилцаа холбооны зардал (утасны нэгж	хүн, нэгж	1	110000	2	төгрөг*хүн* нэгж	220,000
<b>Нийт</b>							<b>29,711,600</b>